

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ТӨРИЙН ӨМЧИТ ЦЭЦЭРЛЭГ
БОЛОН СУРГУУЛИУДААС АВСАН СЭТГЭЛ
ХАНАМЖИЙН СУДАЛГАА**


2021 он

2021 оны 12-р сард Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит цэцэрлэг болон сургуулиудаас түгээгдэж буй бараа бүтээгдэхүүний чанар, үйлчилгээний хүртээмж, түгээлтийн ажилчдын зан харьцаа ёс зүйн талаар 6 асуулга бүхий сэтгэл ханамжийн судалгаа, гал тогоонд хэрэглэгдэж буй тоног төхөөрөмжийн хүртээмж тоо ширхэг, бүтээгдэхүүний нэр төрлөөр төрөлжсөн агуулахтай эсэх, хүртээмж /талбай м2/, хоол үйлдвэрлэл үйлчилгээнд хэдэн хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг, ямар боловсрол мэргэжилтэй зэрэг ажиллах хүчний судалгааг авч ажиллалаа.. Тус судалгаанд нийт 60 цэцэрлэг, 3 сургууль хамрагдахаас 43 цэцэрлэг, 3 сургууль буюу 73% нь хамрагдаж, өөрсдийн бодол, санал хүсэлтээ солилцож, үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Тус асуулгад хамрагдсан цэцэрлэгүүдээс нийт 27 санал ирүүлснээс 24 цэцэрлэгээс бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, үнэтэй холбоотой санал ирүүлсэн бөгөөд 4 цэцэрлэгээс түгээлтийн ажилчдын зан харьцаа сайн, бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол сайн, ажлын амжилт хүссэн байна. Асуулгад:


1. Манай байгууллагын түгээлтэд ажиллаж буй ажилчдын зан харьцааг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуулгад 41% нь маш сайн, 55% нь сайн, 4% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн байна.

а. Маш сайн - 19 б.Сайн – 25 в. Дунд – 2



2. Түгээгдэж буй бараа бүтээгдэхүүний нэр төрөлд үнэлгээ өгнө үү? Гэсэн асуулгад 89% нь хангалттай, 11% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байна


а. Хангалттай - 39 б.Хангалтгүй - 5




3. Түгээгдэж буй бүтээгдэхүүний чанарт үнэлгээ өгнө үү? гэсэн асуулгад 70% нь сайн, 30% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн байна.

а. Сайн – 32


б.Дунд - 14



4. Манай байгууллагад хандан бүтээгдэхүүний стандарт, чанартай холбоотой асуудлыг цаг тухай бүрд шийдвэрлүүлж байсан эсэх? гэсэн асуулгад 48% нь бүтээгдэхүүний чанартай холбоотой асуудлыг шийдвэрлүүлж байсан, 13% нь шийдвэрлүүлж байгаагүй, 39% нь бүтээгдэхүүний стандарт, чанартай холбоотой ямар нэгэн асуудал гарч байгаагүй гэсэн үнэлгээ өгсөн байна.



5. Манай байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгад 28% нь маш сайн, 70% нь сайн, 2% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн байна.



6. Таны бодлоор цаашид бид юу анхаарах шаардлагатай байна вэ? Санал хүсэлтээ бичнэ үү? гэсэн асуулгад нийт 27 цэцэрлэг санал ирүүлснээс 11% нь ажилчдын зан харьцаа сайн, ажлын амжилт хүссэнээ илэрхийлсэн бол 37% нь бараа бүтээгдэхүүний үнэ өндөр, 23% нь бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх /гоймон, жигнэмэг/, 29 нь мах махан бүтээгдэхүүн нь бохирдол ихтэй, хүнсний ногоо зарим тохиолдолд хайрагдсан байдаг бөгөөд сул шороо болон хаягдал ихтэй байна гэж дүгнэсэн байна.



Санал гомдлын мөрөөр авсан арга хэмжээ:

Дээрх судалгаагаар ирсэн гомдол саналын дагуу бэлтгэн нийлүүлэгч гэрээт байгууллагуудтай холбогдон хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг нийлүүлэх, чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг буцаан авч, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр сольж өгч, гомдлыг барагдууллаа. Хүнсний ногоо бэлтгэн нийлүүлэгч “Эрдэнэ-Энх трейд” ХХК-тай холбогдон төмс, болон бусад ногоог дахин ангилж, сорлуулан хаягдалгүй болгох талаар анхааруулав.

Дүгнэлт

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан нийт 46 байгууллагаас хүнсний бүтээгдэхүүний чанар, үзүүлж буй үйлчилгээний хүртээмж, бүтээгдэхүүний нэр төрөл, түгээлтийн ажилчдын зан харьцааны талаар “Хангалттай” үнэлгээ авч ажиллалаа. Дэлхий нийтээр Ковид-19 цар тахал гарч зарим бараа бүтээгдэхүүний хомсдол үүсэж, үнэ өсөж байгаа боловч хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг хүүхдийн хоолны стандарт шаардлага хангасан бүтээгдэхүүнээр төрөлжүүлэн, нэмэгдүүлж, бараа бүтээгдэхүүний үнийг тогтмолжуулах талаар судалгаа хийж байна. Цэцэрлэгүүдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг цаашдын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.